

## 2019 ОНД ЭКСПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Шалгаруулалтын дугаар: СХЭИЗОСШ-20190124

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 77 дугаар тогтоолоор баталсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам”-д заасны дагуу 2019 онд экспортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо, хэмжээнд багтаан зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Үүнд:

Үхрийн мах - 29900 тн /хорин есөн мянга есөн зуу/

Адууны мах – 31000 тн /гучин нэгэн мянга/

Оролцогч нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, битүүмжлэн, **2019 оны 02** дугаар сарын **01**-ний өдрийн 16 цаг 00 минутаас өмнө Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны 504 тоот өрөөнд бүртгүүлж, хүлээлгэн өгнө. Үүнд:

1. Экспортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг заасан албан бичиг;
2. Хуулийн этгээдийн нэр, байршил, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг;
3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, эрхэлж байгаа хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр;
4. Татварын өргүй болохыг тодорхойлсон харъяалах татварын албаны тодорхойлолт;
5. Аудитаар баталгаажсан 2018 оны санхүүгийн тайлан;
6. Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй эсэхийг нотлох баримт бичиг, эсхүл энэ шаардлагыг хангасан агуулахыг түрээслэх тухай хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний нотариатаар баталгаажуулсан хувь;
7. Хуулийн этгээдийг төлөөлөн сонгон шалгаруулалтад оролцох этгээдийн итгэмжлэл бүхий албан бичиг;
8. Импортлогч орны мал эмнэлэг, ургамал, хорио цээрийн албаны эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн байх;
9. Импортлогч талтай байгуулсан худалдааны гэрээ.

Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг хүлээн авах эцсийн хугацаа: **2019 оны 02** дугаар сарын **01**-ний өдрийн 16 цаг 00 минут /Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй/

Сонгон шалгаруулалтыг нээх хугацаа: **2019 оны 02** дугаар сарын **01**-ний өдрийн 17 цаг 00 минут

**ХАЯГ:**

**Монгол Улс, Улаанбаатар-13381, Энхтайваны өргөн чөлөө 16а,  
Засгийн газрын 9 дүгээр байр, Б корпус, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн  
яамны  
5 давхарт, 504 тоот өрөө, Утас: 261962**